



ШҮҮХИЙН СУРГАЛТ,
СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

**ОЛОН УЛСЫН АРБИТРЫН
ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ
АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН
ОРЧИНТОЙ ХОЛБООТОЙ
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

СУДАЛГААНЫ САН: ИХ/00/2023/05/23

ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ
2023.05.10

ТОВЬЁГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
УДИРТГАЛ	4
НЭГ. ГАДААДЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ БИЕЛҮҮЛЭХ	5
ТУХАЙ ОЙЛГОЛТ	5
ХОЁР. АРБИТРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ШҮҮХИЙН ОРОЛЦОО БА ГАДААДЫН АРБИТРЫН ШИЙДВЭРИЙГ	7
ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ	7
ГУРАВ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА	8
ДҮГНЭЛТ	17
ЭХ СУРВАЛЖ	19

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ШССМХ	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн
ШХУ	Швейцарын Холбооны Улс
ЮНСИТРАЛ	НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс

УДИРТГАЛ

Судлах зүйл

Судалгааны ажлын хүрээнд гадаад улсын хууль тогтоомж, олон улсын хэм хэмжээнээс дараах асуудлын хүрээнд дэлгэрүүлэн судаллаа:

1. Олон улсын арбитрын шийдвэрийг биелүүлэхэд Үндэсний хууль тогтоомжтой зөрчилдөж буй тохиолдолд хэрхэн шийдвэрлэх;
2. Арбитрын шийдвэрийг биелүүлж буй олон улсын жишиг;
3. Арбитрын шийдвэрийг биелүүлэхээс татгалзах үндэслэлд юу хамаарах.

Судалгааны хамрах хүрээ

Судлах зүйлийн хүрээнд Монгол Улсын олон улсын гэрээ буюу 1958 оны Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенц, ийнхүү биелүүлэхээр татгалзах үндэслэлийн талаар онолын ойлголтоос гадна Япон Улс, Швейцарын Холбооны Улс, Бүгд Найрамдах Сингапур Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын эрх зүйн зохицуулалтыг сонгон авч харьцуулан судалсан болно.

Судалгааны арга зүй

Судалгааг хийж хийж гүйцэтгэхдээ харьцуулан судлах, нэгтгэн дүгнэх арга зүйг ашигласан.

Судалгааны бүтэц

Энэхүү судалгаа нь Гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх тухай ойлголт, Арбитрын үйл ажиллагаан дахь шүүхийн оролцоо ба гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх тухай, Харьцуулсан судалгаа, Дүгнэлт, Эх сурвалж гэсэн хэсгээс бүрдэнэ.

НЭГ. ГАДААДЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ ОЙЛГОЛТ¹

Гадаад улсын шүүхийн шийдвэр ямар нөхцөлд нутаг дэвсгэр дээр нь хүчинтэй байх эсэхийг аливаа улс өөрөө тогтоодог. Res Judicata (аливаа маргаан нь эцэслэн шийдвэрлэгдсэн бол хүлээн зөвшөөрөгдөх ёстой) зарчмын үндсэн дээр шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх асуудал хэрэгжих үндэс болдог. Өөрөөр хэлбэл, нэгэнт шийдвэрлэгдсэн хэргийн талаар талууд хэргийг шийдвэрлэсэн шүүхэд дахин хандах эсхүл өөр шүүхэд хандах эрх зүйн үндэслэлгүй гэсэн үг. Үүнтэй холбоотойгоор гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх асуудал үүсэх ба **гадаад улсын шүүхийн шийдвэр гэдэгт тухайн маргаантай асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг ойлгоно.**

Албадан гүйцэтгүүлэх шийдвэр нь хуулийн хүчин төгөлдөр болсон, шийдвэрийн үнэн зөв байдал нь түүнийг гаргасан шүүхээр баталгаажсан, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг тухайн шүүх зөвшөөрсөн, шийдвэрийн эх албан ёсоор орчуулагдсан зохих журмын дагуу ирүүлсэн байх шаардлагатай.

Улсууд гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх олон улсын үүрэг хүлээдэггүй ч найрсаг харилцаанд үндэслэн аль болох татгалзахгүй байх ёстой. **Шийдвэрийг биелүүлж, хэрэгжүүлэх улсын хуулиар тогтоосон шаардлагыг хангаж байвал гадаадын шүүхийн шийдвэр нь үндсэндээ хүлээн зөвшөөрөгдөх ёстой².** Энэ шалгуур нь мэдээж улс бүрд харилцан адилгүй боловч дараах нийтлэг хоёр нөхцөл бий. Үүнд: 1/ гадаадын шүүх хэргийг харьяалах эрх хэмжээтэй байх, 2/ нийтийн дэг журамд нийцэх явдал юм. Нийтийн дэг журмын гол үндэс нь Үндсэн хууль байдаг ба нийтийн дэг журмыг зөрчинө гэдэг нь үндсэндээ хүний эрхийг зөрчиж байна гэсэн үг юм.

Мөн аливаа улсын дотоодын шүүх гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхөд дараах асуудлыг шалгана³:

- Шийдвэр гаргасан шүүх хэрэг харьяалах эрх хэмжээгээ хэтрүүлээгүй байх;
- Гадаадын шүүхийн шийдвэр нь эцсийн байх;
- Хэргийн талууд нэг ижил байх;
- Хүлээн зөвшөөрөх эрх мэдэл ба шаардлага байгаа эсэх;
- Гадаадын шүүх зохигчдын процессын эрхийг хангасан эсэх;
- Эсрэг утгатай шийдвэр байгаа эсэх;
- Процессын ба материаллаг эрх зүйн *ordre public* заалтыг харгалзах;
- Харилцан адил байх зарчим мөрдөгдөж буйг тус тус шалгана.

Түүнчлэн энэхүү асуудлаарх олон улсын эрх зүйн хэм хэмжээ буюу эх сурвалж болдог 1958 оны Нью-Йоркийн Конвенц болох Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенцын зохицуулалтыг нэн тэргүүнд авч үзэх шаардлагатай. Холбогдох зохицуулалтаас дурдвал:

ГАДААДЫН АРБИТРЫН ШИЙДВЭРИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ, БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ КОНВЕНЦ	
Конвенцын зүйл, заалт	Заалтын агуулга

¹ Б.Тамир, *Олон улсын хувийн эрх зүй*, (УБ,2019), 253-273 дахь тал.

² Мөн тэнд. 253 дахь тал.

³ Мөн тэнд. 259-260 дахь тал.

<p>3 дугаар зүйл</p>	<p>Хэлэлцэн тохирогч улс бүр арбитрын шийдвэрийг заавал биелүүлэх шийдвэр гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд түүнийг өөрийн улсын хэрэг хянан шийдвэрлэх эрхийн хэм хэмжээг баримтлан доорх зүйлүүдэд заасан нөхцөлөөр биелүүлнэ. Энэхүү конвенцод хамаарах арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхэд дотоодын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхээс илт давуу хүнд нөхцөл буюу өндөр хураамж, татварыг хэрэглэж болохгүй.</p>
<p>5 дугаар зүйл</p>	<p>1. Арбитрын шийдвэрээр хариуцлага хүлээх тал гагцхүү дараах нотолгоог эрх бүхий байгууллагад гаргаж өгсөн нөхцөлд арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхээс татгалзаж болно:</p> <p>(a) 2 дугаар зүйлд заасан хэлэлцээр байгуулсан талууд тэдгээрт хэрэглэх хуулиар эрх зүйн чадамжгүй байсан, эсхүл талууд хэлэлцээр байгуулахдаа баримталсан буюу хэрэв үүнийг заах боломжгүй бол арбитрын шийдвэр гаргасан улсын хууль тогтоомжийн дагуу уг хэлэлцээр хүчингүй болсон;</p> <p>(b) арбитрчийг томилох буюу хэргийг арбитраар хянан шийдвэрлэх талаар хариуцагч талд зохих ёсоор мэдэгдээгүй, эсхүл хариуцагч тал нь бусад шалтгаанаар тайлбараа гаргаж өгч чадаагүй;</p> <p>(c) арбитрын хэлэлцээр буюу гэрээнд оруулсан арбитрын заалтын нөхцөлд тусгаагүй буюу түүнд заасан хэмжээнээс хэтэрсэн асуудлаар шийдвэр гаргасан; гэхдээ энэ тохиолдолд хэрэв арбитрын хэлэлцээрт заасан асуудлаар гарсан шийдвэрийн заалтыг арбитрын хэлэлцээрт заагаагүй асуудлаар гарсан шийдвэрийн заалтаас зааглан салгаж болох бол арбитраар шийдвэрлүүлэхээр хэлэлцээрт заасан асуудлын талаар гаргасан шийдвэрийн зарим хэсгийг хүлээн зөвшөөрч, албадан биелүүлж болно;</p> <p>(d) арбитрын бүрэлдэхүүн буюу арбитрын хэрэг хянан хэлэлцэх ажиллагаа талуудын байгуулсан хэлэлцээрт нийцээгүй эсхүл ийм хэлэлцээр байгуулаагүй бол арбитрын шийдвэр гаргасан орны хуулийг зөрчсөн;</p> <p>(e) арбитрын шийдвэр талуудын хувьд эцсийнх болоогүй эсхүл шийдвэр гаргасан буюу хууль тогтоомжийг нь хэрэглэсэн улсын эрх бүхий байгууллагаас шийдвэрийг хүчингүй болгосон буюу шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлсэн.</p> <p>2. Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх орны эрх бүхий байгууллага дараах тохиолдолд түүнийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхээс татгалзаж болно:</p> <p>(a) тухайн орны хууль тогтоомжоор уг маргааны объект нь арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зүйл байж болохгүй бол;</p> <p>(b) арбитрын тухайн шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх явдал нь тухайн орны нийтийн дэг журамд харшилж байвал.</p>
<p>6 дугаар зүйл</p>	<p>Энэхүү конвенцын 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (e) дэд хэсэгт заасан эрх бүхий байгууллагад арбитрын шийдвэрийг биелүүлэхийг хүчингүй болгох, түдгэлзүүлэх тухай хүсэлт гарвал шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай хүсэлт хүлээн авагч байгууллага, энэхүү шийдвэрийг</p>

	зөвшөөрөх, биелүүлэх ажиллагааг хойшлуулах шаардлагатай гэж үзвэл, шийдвэрийг зөвшөөрөх, биелүүлэх хүсэлт гаргасан талын хүсэлтээр нөгөө талаас шийдвэрийн биелэлтийн баталгаа гаргахыг үүрэг болгож болно.
ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ	
194 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх	Монгол Улсын шүүхийн болон гадаад улсын шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх журам нь Монгол Улсын хууль тогтоомж, гадаад улстай байгуулсан буюу Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр тодорхойлогдоно.
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬ	
116 дугаар зүйл. Гадаад улсын болон олон улсын шүүх, арбитрын шийдвэрийг гүйцэтгэх	Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаад улсын, олон улсын шүүх, арбитрын шийдвэрийг гүйцэтгэх журмыг энэ хууль, Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлно.

Дээрхээс гадна ихэнх тохиолдолд, Иргэний хэргийн асуудлаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх Монгол Улсын хоёр талт болон олон улсын ихэнх гэрээнд гэрээний нөгөө талын шүүхийн болон арбитрын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх талаар тодорхой бүлэг болгон зохицуулсан байдаг. Жишээлбэл: Монгол Улс болон БНХАУ-ын хооронд байгуулагдсан хоёр талт гэрээний 18 дугаар зүйлд “Дараах тохиолдолд шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх болон биелүүлэхээс татгалзана. Үүнд:

- а/ Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болоогүй буюу биелэх боломжгүй;
- б/ Хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжийн дагуу уг хэргийг эрхлэх эрхгүй;
- в/ Байцаан шийдвэрлэх ажиллагаанд оролцоогүй зохигчдыг албан ёсоор дуудаагүй буюу байцаан шийтгэх ажиллагаанд оролцох чадваргүй байсан үед нь тэдний хууль ёсны төлөөлөгч оролцоогүй бол;
- г/ Зохигчдын хооронд үүссэн нэг төрлийн хэргийн талаар хүчин төгөлдөр шийдвэр гаргасан, мөн хэргийн талаар байцаан шийтгэх ажиллагаа явуулж эхэлсэн, уг хэргийн талаар гурав дахь улсад гарсан хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн бол” гэж зохицуулжээ.

Харин Монгол Улс Швейцарын холбооны улсын хооронд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгаа эсэхийг хайхад олдоогүй боловч 1997 онд байгуулж 1999 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Хөрөнгө оруулалтын хоёр талт хэлэлцээр байна. Гэсэн хэдий ч тус хэлэлцээрт гадаадын шүүхийн эсхүл арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхтэй холбоотой заалт байгаагүй⁴ болно.

ХОЁР. АРБИТРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ШҮҮХИЙН ОРОЛЦОО БА ГАДААДЫН АРБИТРЫН ШИЙДВЭРИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ⁵

Арбитрын хэлэлцээрийн үндсэн дээр маргаанаа арбитраар шийдвэрлүүлэхээр тохиролцсон явдал нь уг маргаан дахь шүүхийн оролцоог хязгаарладаг. Гэвч процессын ажиллагааны хувьд шүүхийн оролцоо байна. Шүүхийн зүгээс арбитрын үйл ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжийг хангах үүднээс хязгаарлагдмал тохиолдолд шүүхийн оролцоог зөвшөөрдөг. 1985 онд НҮБ-ын Худалдааны эрх зүйн комиссын олон

⁴ <https://investmentpolicy.unctad.org/international-investment-agreements/treaty-files/4666/download> (Сүүлд үзсэн: 2023.04.25).

⁵ Б.Тамир, *Олон улсын хувийн эрх зүй*, (УБ,2019), 282-287 дахь тал.

улсын арилжааны арбитрын загвар хууль батлагдаж, арбитрын ажиллагаанд шүүхийн оролцоог хязгаарласан.

Арбитрын шийдвэрт шүүхийн хяналт нь үндэсний шүүх ба арбитрын хоорондох харилцааны чухал цэг юм. Арбитрын ажиллагаанд оролцож байгаа талууд хуульд заасан үндэслэлээр арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай хүсэлтийг тухайн арбитрын ажиллагаа явагдсан нутаг дэвсгэрийн давж заалдах шатны шүүхэд гаргаж болно. Дараах үндэслэлээр арбитрын шийдвэрийг хүчингүй болгож болно⁶:

- Арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр бус байсан;
- Тухайн маргаан нь уг арбитрын харьяаллын маргаан биш байсан нь нотлогдсон;
- Арбитрын бүрэлдэхүүн талуудын эрхийг хангаагүй;
- Арбитрын ажиллагааны журмыг зөрчсөн;
- Арбитрын бүрэлдэхүүн арбитрын хэлэлцээрт хамаарахгүй асуудлаар шийдвэр гаргасан;
- Арбитрын шийдвэр нь нийтийн дэг журмыг зөрчсөн нь нотлогдсон зэрэг юм.

Товчхондоо, шүүх талуудын хүсэлтээр арбитрын ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих ба арбитрын шийдвэрийг баталгаажуулж, хэрэгжихэд туслалцаа үзүүлнэ.

Арбитрын шийдвэрийг биелүүлэх буюу аль нэг улсын арбитрын шийдвэрээр төлбөр төлөгч өөр улсын нутаг дэвсгэрт оршин байгаа тохиолдолд уг шийдвэрийг хэрхэн биелүүлэх нь үндэсний ба олон улсын процессын эрх зүйн хэм хэмжээг хослуулан хэрэглэх шаардлагатай өвөрмөц ажиллагаа юм. Энэ нь дэлхийн улсуудын эрх зүйн тогтолцоо, хуулийн үзэл баримтлал, улс төрийн бүтэц, дэглэм өөр өөр байдагтай холбоотой.

Тиймээс 1958 оны Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх тухай конвенц нь түүнд оролцогч ба оролцогч бус бусад оронд гарсан арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх хамгаалалтын тогтолцоог бүрдүүлсэн онцлогтой. Өөрөөр хэлбэл, аливаа гадаад улсын нутаг дэвсгэр дээр гарсан арбитрын шийдвэрийг нөгөө улс хүлээн зөвшөөрч биелүүлэх ёстой.

Гадаадын арбитрын шийдвэрийг хэрэгжүүлэхээс өмнө дотоодын шүүх арбитрын хэлэлцээр нь хүчин төгөлдөр бус, талуудын процессын эрх зөрчигдсэн, шийдвэрийг хэрэгжүүлэх улсын хуулийн дагуу тухайн маргаан нь арбитрын харьяаллын маргаан биш, дотоодын нийтийн дэг журмын эсрэг гэж үзсэн бол хэрэгжүүлэхээс татгалзана.

ГУРАВ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

3.1. Япон Улсын эрх зүйн орчинд хийсэн судалгаа

Япон улс нь 1985 оны “Олон улсын арилжааны арбитрын тухай хууль”-д үндэслэн 2003 онд “Арбитрын тухай хууль”-ийг баталсан⁷. Тус хууль нь нийт 10 бүлэг, 55 зүйлээс бүрдэх бөгөөд арбитрчийг хэрхэн сонгох, арбитрын хэлэлцээр болон ажиллагаа, арбитрын шийдвэр, түүнийг биелүүлэх тухай шийдвэрийн талаар зохицуулсан. Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай 1958 оны конвенц болон Арбитрын тухай хууль (ялангуяа 45 дугаар зүйл) нь олон улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулдаг чухал ач холбогдолтой. Олон улсын арбитрын шийдвэр гарсны дараа тус шийдвэрийг талууд хүлээн зөвшөөрч (仲裁判断の承認),

⁶ Мөн тэнд. 283 дахь тал.

⁷ 仲裁法（平成十五年法律第三十八号）, уг хуулийн англи хувилбарыг дараах холбоосоор үзнэ үү <https://www.japaneselawtranslation.go.jp/ja/laws/view/2784>.

шүүх биелүүлэх тухай шийдвэр (仲裁判断の執行決定) гаргаснаар биелэгдэх боломжтой болдог.

Олон улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах

Арбитрын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1-т заасны дагуу олон улсын арбитрын шийдвэр нь тус зүйлийн 45.2-т заасан “хүлээн зөвшөөрөхөөс татгалзах үндэслэл”-д хамаарахгүй бол гарсан даруйдаа “автоматаар (自動承認主義)” Япон улсын дотор хүчин төгөлдөр болно⁸. Тодруулбал, ① арбитрын хэлэлцээрийн хүчин төгөлдөр байдалтай холбоотой үндэслэл (Арбитрын тухай хуулийн 45.2.1 болно 45.2.2), ② арбитрын ажиллагаа зохистой явагдсан эсэхтэй холбоотой үндэслэл (Арбитрын тухай хуулийн 45.2.3-аас 45.2.6), ③ арбитрын шийдвэрийн хүчин төгөлдөр байдалтай холбоотой үндэслэл (Арбитрын тухай хуулийн 45.2.7), ④ Япон улсын олон нийтийн дэг журамтай холбоотой үндэслэл (Арбитрын тухай хуулийн 45.2.8 болно 45.2.9) байгаа тохиолдолд олон улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж болно.

Олон улсын арбитрын шийдвэрийг биелүүлэх тухай шийдвэр

Шүүхээс талуудын мэтгэлцээний зарчим болон оролцоог хангасны үндсэн дээр арбитрын шийдвэрийг биелүүлэх тухай шийдвэрийг шаардах өргөдлийг хэлэлцэж, шийдвэр биелүүлэх тухай шийдвэр гаргадаг⁹. Арбитрын шийдвэрийг биелүүлэх тухай шийдвэр гаргахыг шаардах өргөдлийг үүрэг гүйцэтгэгчийн (債務者) оршин суугаа газрын анхан шатны шүүх (地方裁判所), нэхэмжлэлийн шаардлага эсхүл үүрэг гүйцэтгэх хөрөнгийн байгаа газрын анхан шатны шүүх, оролцогчдын тохирсон анхан шатны шүүхэд гаргана (Арбитрын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.4). Тус хуульд зааснаас бусад үндэслэлээр олон улсын арбитрын шийдвэрийг биелүүлэх тухай шийдвэрийг биелүүлэхээс татгалзах боломжгүй бөгөөд энэ нь “агуулгыг дахин хянахыг хориглох (実質的再審査の禁止)” тухай онолын үзэл баримтлалтай холбоотойгоор тайлбарлагддаг¹⁰.

Арбитрын шийдвэрийг биелүүлэх тухай шийдвэрийг биелүүлэхээс татгалзах үндэслэл нь арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах үндэслэлтэй адилхан байна. Дэлгэрүүлэн авч үзвэл дараах үндэслэлүүд хамаардаг:

- Талуудын эрх зүйн чадамжгүй байдлаас шалтгаалан арбитрын хэлэлцээр нь хүчин төгөлдөр бус тохиолдолд;
- Арбитрын хэлэлцээрт хэрэглэхээр тохиролцсон хууль тогтоомжийн дагуу тухай арбитрын хэлэлцээр нь хүчин төгөлдөр бус (талуудын эрх зүйн чадамжгүйгээс өөр шалтгаанаар) тохиолдолд;
- Талууд нь арбитрч томилох болон арбитрын ажиллагааны тухай арбитрын шүүхийн байрлаж буй улсын хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор мэдэгдэл хүлээн аваагүй тохиолдолд;
- Талуудын аль нэг нь арбитрын ажиллагаанд өөрийгөө хамгаалж оролцох боломжгүй байсан тохиолдолд;
- Арбитрын шийдвэр нь арбитрын хэлэлцээр болон ажиллагааны тухай өргөдлийн хүрээнээс хэтэрсэн асуудлыг шийдсэн тохиолдолд;
- Арбитрын бүрэлдэхүүн эсхүл арбитрын ажиллагаа нь арбитрын шүүх байрлах улсын хууль тогтоомжийг (тухайн хууль тогтоомжийн нийтийн дэг журамд хамаарахгүй

⁸ 近藤昌昭ほか『仲裁法コンメンタール』（商事法務、2003）263頁。

⁹ 仲裁法46条10項が準用する44条5項。なお、谷口安平＝鈴木五十三編『国際商事仲裁の法と実務』（丸善雄松堂、2016）452頁。

¹⁰ Агуулгыг дахин хянахыг хориглох тухай асуудал нь арбитрын шийдвэрийг хүчингүй болгохтой холбоотойгоор хөндөгддөг үзэл баримтлал юм. Тухайлбал, талууд шүүхээр дахин хянуулах тухай тохиролцсон байсан үед энэ тухай асуудал хөндөгдөнө.

高杉直『日本における外国判決 および外国仲裁判断の承認・執行』法政論集 276号（2018）。

заалтын тухай талуудын тохиролцоо байгаа бол тухай тохиролцоог) зөрчсөн тохиолдолд,

- Арбитрын шүүхийн байрлах улсын (арбитрын ажиллагааны үндэслэл болсон хууль тогтоомж нь арбитрын шүүх байрлах улсаас өөр улсын хууль байвал, тухайн улс) хууль тогтоомжийн дагуу арбитрын шийдвэр нь хүчин төгөлдөр болоогүй, эсхүл арбитрын шийдвэр нь тухайн улсын шүүхээр хүчингүй болсонд тооцогдсон тохиолдолд;
- Япон улсын хууль тогтоомжийн дагуу тухай арбитрын ажиллагааны өргөдөл нь арбитрын хэлэлцээрт хамаарах маргаан биш тохиолдолд;
- Арбитрын шийдвэрийн агуулга нь Япон улсын нийтийн дэг журам (公の秩序) эсхүл сайн сайхан заншил (善良の風俗)-д нийцэхгүй тохиолдолд шүүхэд олон улсын арбитрын шийдвэрийг биелүүлэхээс татгалзах тухай өргөдөл гаргаж болно.

Олон улсын арбитрын шийдвэрийг биелүүлэхтэй холбоотой шүүхийн тайлбар

Япон улсын шүүх нь олон улсын арбитрын шийдвэрийг “хүндлэх (尊重する)” хандлагатай байгааг олон жишээнээс харж болно¹¹. Тухайлбал: Токиогийн анхан шатны шүүх “арбитр нь талуудын **тохиролцоон дээр** үндэслэн шүүхийн бус журмаар явагддаг ажиллагаа бөгөөд **давж заалдах гомдол гаргах ажиллагаа** (давж заалдах журмаар дахин хэлэлцэх) **анхнаасаа төлөвлөгдөөгүй** байдаг. Тиймээс **тухайн арбитрын шийдвэр нь эцсийн шийдвэр байх** ба**арбитрын шийдвэр нь хүндлэгдэх ёстой** (尊重されるべき)¹² гэсэн байна.

Мөн Токиогийн давж заалдах шатны шүүх “арбитрын шийдвэрийг хүчингүй болгохоор гаргасан өргөдөлтэй холбоотой хэргийн тухайд **арбитрын шийдвэрийг агуулгын хувьд дахин хэлэлцэх нь хүлээн зөвшөөрөгдөхгүй**” гэсэн бөгөөд “тухайн арбитрын шийдвэр нь хэргийн үйл баримт болон хуулийн хэм хэмжээг алдаатай хэрэглэсэн байх байх магадлалтай байсан ч **арбитрын байрлах улсын шүүх нь тус алдааг үндэслэл болгон арбитрын шийдвэрт оролцож, хүчингүй болгохгүй**”¹³ гэж тайлбарласан байна.

Дээрхээс үзэхэд, Япон улсын хувьд олон улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах, хүчингүй болгох, биелүүлэхээс татгалзах үндэслэлүүдийг хуульд тусгайлан заасан байна. Гэвч шүүхээс олон улсын арбитрын шийдвэрийг хүндэтгэх, хуульд заасан үндэслэл нь “ноцтой” л биш бол тухайн шийдвэр нь заавал биелэгдэх ёстой гэж тайлбарлах хандлагатай байна.

3.2. Швейцарын Холбооны Улсын эрх зүйн орчинд хийсэн судалгаа

ШХУ-ын хувьд дэлхийн бусад улсын нэгэн адилаар энэхүү харилцаанд үйлчилдэг олон улсын эрх зүйн эх сурвалж нь 1958 оны Нью-Йоркийн Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх тухай конвенц юм. Дээрх конвенцод ШХУ 1958 онд гарын үсэг зурж 1965 оноос хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлсэн¹⁴ байна.

Тус конвенц нь гадаад улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, түүнийг биелүүлэх тухай зохицуулалтууд агуулснаас гадна арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээс татгалзах хэд хэдэн үндэслэлийг ерөнхий байдлаар тусгасан байдаг. Тус

¹¹ Kazushige Ogawa, Introduction to Japanese Arbitration Act with Court Cases, [https://idrc.jp/images/link/Introduction%20to%20Japanese%20Arbitration%20Act%20with%20Court%20Cases%20\(Japanese\).pdf](https://idrc.jp/images/link/Introduction%20to%20Japanese%20Arbitration%20Act%20with%20Court%20Cases%20(Japanese).pdf), 2.

¹² 東京地決平成 21・7・28(平成 20 年(仲)3 号)LEX/DB 文献番号: 25451576、判タ 1302 号 292 頁

¹³ 東京高決平成 30・8・1(金商 1551 号 13 頁)

¹⁴ <https://www.newyorkconvention.org/countries>, (Сүүлд үзсэн: 2023.04.23).

зохицуулалтуудыг ШХУ-ын хувьд хуулиараа нарийвчлан зохицуулсан байдаг ба энэ талаар доорх хэсэгт дэлгэрэнгүй авч үзэв.

ШХУ-ын Олон улсын арбитр нь олон жилийн арвин түүхтэй, төвийг сахин олон маргааныг үр дүнтэй шийдвэрлэж буй нэр хүндтэй байгууллага юм. ШХУ-ын хувьд эрх зүйн тогтолцоо нь нийтлэг эрх зүйн тогтолцооны жишгээр АНУ болон бусад нийтлэг эрх зүйн тогтолцоонд хамаарах улсуудынхтай адил бус иргэнлэг эрх зүйн буюу эх газрын эрх зүйн тогтолцооны системд суурилдаг. Тус улсад арбитрын үйл ажиллагаа явуулдаг байгууллагаас дурдвал: ШХУ-ын Арбитрын танхимууд, Олон улсын худалдааны арбитрын танхим (*International Chamber of Commerce*), Спортын арбитрын хэргийн танхим (*Court of Arbitration for Sport*) зэрэг багтана¹⁵.

Тус улсын арбитрын хуулиуд нь талуудын бие даасан байдал болон нууцлалд онцгойлон анхаардаг орчин үеийн уян хатан зохицуулалттай гэж судлаачид онцолдог. Эрх зүйн гол эх сурвалж нь UNCITRAL-ийн Олон улсын худалдааны арбитрын тухай загвар хуульд үндэслэсэн ШХУ-ын Олон Улсын Хувийн Эрх зүйн тухай хууль (*The Swiss Federal Act on International Private Law*) юм¹⁶.

Энэхүү хуулиар Швейцарь дахь олон улсын арбитрын үйл ажиллагааны хүрээг тодорхойлдог бөгөөд олон улсын элемент агуулсан хувийн эрх зүйн харилцааг зохицуулдаг. Тус хуулийн 17 дугаар зүйлд “Гадаад улсын хуулийг хэрэглэхэд тэр нь ШХУ-ын нийтийн дэг журам /order public/ ¹⁷-д нийцэхгүй бол тухайн хуулийг хэрэглэхээс татгалзана” гэж зохицуулснаас гадна 27 дугаар зүйлд Гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байх үндэслэл, 190 дүгээр зүйлд Хойшлуулах арга хэмжээний тухай тусгажээ.

27 дугаар зүйл. Гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байх үндэслэл¹⁸

1. Хэрэв хүлээн зөвшөөрөх нь ШХУ-ын нийтийн эрх ашгийн /нийтийн дэг журам буюу order public/ талаарх бодлоготой илт нийцэхгүй бол гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй.
2. Маргааны аль нэг тал дараах үндэслэлээр шийдвэрийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж болно:
 - а. Маргааны аль нэг тал нь үндэслэлгүйгээр процесс ажиллагааг үргэлжлүүлээгүй эсхүл өөрийн оршин суугаа газрын болон байнгын оршин суугаа газрынхаа хуулийн дагуу зохих мэдэгдлийг хүлээн аваагүй бол;
 - б. ШХУ-ын хэрэг хянан шийдвэрлэх хуулийн үндсэн зарчмуудыг зөрчсөн шийдвэр гаргасан, тэр дундаа холбогдох тал шүүх хуралдаанд оролцох эрхийг хангахгүйгээр шийдвэр гаргасан бол;

¹⁵ <https://www.swissarbitration.org/swiss-arbitration-centre-new-court-members-as-of-january-2023/> <https://www.tas-cas.org/en/general-information/index/> <https://www.swissarbitrationdecisions.com/> (Сүүлд үзсэн: 2023.04.23).

¹⁶ <https://www.unil.ch/files/live/sites/cedidac/files/Articles/Intro%20Sw%20Law.pdf> (Сүүлд үзсэн: 2023.04.23).

¹⁷ ШХУ-ын арбитрын ажиллагааны хүрээнд Олон улсын хувийн эрх зүйн тухай хуулийн Англи хэл дээрх орчуулгад тэмдэглэсэн **“төрийн бодлого” буюу “public policy” гэснийг Олон улсын гэрээний орчуулгад нийтийн эрх ашиг эсхүл нийтийн дэг журам буюу “order public”** гэсэн нэр томъёогоор тэмдэглэсэн нь Швейцарын эрх зүйн тогтолцоонд зайлшгүй шаардлагатай гэж үздэг ёс суртахуун, шударга ёсны хамгийн үндсэн зарчмуудыг хэлдэг. Эдгээр зарчмууд нь Швейцарын Үндсэн хууль, холбооны хууль тогтоомж, олон улсын төрийн бодлого зэргээс үүдэлтэй. **Арбитрын шийдвэрийг төрийн бодлогын үндсэн дээр Швейцарь улсад хүчингүй болгох, хүлээн зөвшөөрөхөөс татгалзахын тулд төрийн бодлогыг зөрчсөн байдал нь Швейцарын хуулийн үндсэн зарчмуудтай харшилж, эрх зүйн системд нөлөөлж иргэдийн ухамсрыг цочирдуулахуйц ноцтой байх ёстой.** Энэ бол өндөр шалгуур бөгөөд шударга ёс, ёс суртахууны хамгийн үндсэн зарчмуудыг тодорхой бөгөөд ноцтой зөрчсөн байхыг шаарддаг. Швейцарын шүүхүүд арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс татгалзах үндэслэл болох “төрийн бодлогыг” ашиглахдаа маш болгоомжтой, ханддаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Талуудын бие даасан байдлын зарчмыг Швейцарын арбитрт нухацтай авч үздэг бөгөөд төрийн бодлогыг илт зөрчөөгүй тохиолдолд шүүхүүд арбитрын ажиллагааны үр дүнд хөндлөнгөөс оролцох дургүй байдаг. <https://dergipark.org.tr/tr/download/article-file/1752140>. <https://www.swissarbitrationdecisions.com/definition-public-policy-reaffirmed>. (Сүүлд үзсэн: 2023.04.23).

¹⁸ https://www.fedlex.admin.ch/eli/cc/1988/1776_1776_1776/en. (Сүүлд үзсэн: 2023.04.23).

в. ШХУ-д талуудын хооронд болон тухайн маргааныг анх үүсгэсэн эсвэл тэнд аль хэдийн шийдвэрлэсэн эсхүл ийм маргааныг өмнө нь гуравдагч мужид шийдвэрлэсэн бол сүүлчийн шийдвэр нь тус улсад хүлээн зөвшөөрөх шаардлагыг хангасан тохиолдолд.

3. Дээр дурдсанаас бусад тохиолдолд гадаадын шүүхийн аливаа шийдвэрийг биелүүлэхгүй хэмээн түдгэлзүүлж болохгүй.

190 дүгээр зүйл. Хойшлуулах арга хэмжээ

1. Арбитрын шийдвэрийг мэдэгдсэн цагаас эцсийнх болно.
2. Арбитрын шийдвэрийг зөвхөн дараах тохиолдолд биелүүлэхээс түдгэлзэж болно:
 - а. арбитрын шүүхийн цорын ганц гишүүн буруу томилогдсон эсхүл арбитрын шүүхийн бүрэлдэхүүнийг байгуулсан нь хуульд нийцээгүй бол;
 - б. арбитраас шүүх харьяаллыг хүлээн зөвшөөрсөн нь буруу байсан эсхүл хүлээн авах ёстой байсан ч аваагүй тохиолдолд;
 - в. арбитрын шүүх түүнд гаргасан нэхэмжлэлийн шаардлагаас хальж хэтрүүлэн шийдвэр гаргасан, эсхүл нэхэмжлэлийн шаардлагаас аль нэгийг нь шийдвэрлэж чадаагүй бол;
 - г. талуудад тэгш хандах зарчим, эсхүл тэднийг мэтгэлцэх боломжоор хангаагүй, процессын эрхийг зөрчсөн тохиолдолд;
 - д. арбитрын шийдвэр нь нийтийн эрх ашгийн /нийтийн дэг журам буюу order public/ талаарх бодлоготой нийцэхгүй байгаа тохиолдолд.
3. Арбитрын урьдчилсан хэлэлцүүлгийн шатны шийдвэрийн тухайд дээр дурдсан 2(а) ба 2(б) зүйлийн үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цуцалж болно; энэ тохиолдолд хугацаа нь шийдвэр гардуулснаас хойш үргэлжилнэ.
4. Давж заалдах өргөдөл гаргах эцсийн хугацаа нь шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 30 хоног байна.

3.3. Бүгд Найрамдах Сингапур Улсын эрх зүйн орчинд хийсэн судалгаа

Сингапур улс нь 1986 оны 08 дугаар сарын 21-ний өдөр “Гадаадын Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх биелүүлэх тухай” 1958 оны Нью – Йоркын конвенцод нэгдэн орсон. Конвенцыг хэрэгжүүлэхээр анхлан Арбитрын тухай хуулийг (гадаадын арбитрын шийдвэрийг биелүүлэх) 1986 онд баталсан. Тус хуулийг хожим ЮНСИТРАЛ-ын загвар хуульд суурилсан Олон улсын Арбитрын хуулийг (цаашид “ОУАХ” гэх) баталснаар 1994 онд хүчингүй болгосон бөгөөд шинээр батлагдсан хууль нь конвенцын хэрэгжилтийг үргэлжлүүлэн биелүүлэх болсон. ОУАХ-ийг 2 удаа шинэчлэн найруулж, 5 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд хамгийн сүүлд 2012 онд өөрчлөлт оруулжээ. 1994 – 2012 оны хооронд ОУАХ-ийн зохицуулалтууд нь конвенцын агуулгыг илэрхийлж, төдийлөн өөрчлөгдөөгүй.

Арбитрын шийдвэрийг биелүүлэхээс татгалзах үндэслэл буюу Сингапур улсын жишиг

Гадаадын Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай 1958 оны Нью-Йоркын конвенцийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх орны эрх бүхий байгууллага нь түүнийг биелүүлэхээс татгалзах үндэслэлүүдийг заасан байдаг.¹⁹ Үүнд:

- (а) тухайн орны хууль тогтоомжоор уг маргааны объект нь арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зүйл байж болохгүй бол;
- (b) арбитрын тухайн шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх явдал нь тухайн орны нийтийн дэг журамд харшилж байвал.

Маргааны зүйл нь Арбитрын шүүхийн хяналтын объект биш байх

Сингапур улсын хувьд ОУАХ-ийн (1994) 31 дүгээр зүйлийн 4(b) заалтад тус конвенцын 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан 2 үндэслэлийг тэр хэвээр нь буулгаж баталсан байдаг. Үүний эхний үндэслэл болох Арбитрын харьяалан шийдвэрлэх маргаан биш буюу арилжааны эрх зүйн шинжгүй маргаан гэх үндэслэлээр *Доналд ба Мкартийн эсрэг Хайнан Машинэрийн хэрэг*²⁰ Арбитрын шийдвэрийг эсэргүүцэж маргааны нэг тал нь

¹⁹ Dr.Reinmar, *New York Convention:Article-by-Article-Commentary* (Munchen, Germany: Hart Publishing, 2019) 250-251.

²⁰ *Hainan Machinery v Donald & McArthy* (CLF1-96 (channeo.sg))

Сингапурын Дээд шүүхэд гомдол гаргасан. Гэвч гомдол гаргагч тал үндэслэлээ дэлгэрүүлэн тайлбарлахдаа талууд гэрээний үүргийн зөрчлөөс үүдэлтэй маргааныг шийдвэрлэх хуулиа сонгож чадаагүй тул шийдвэрийг биелүүлэх боломжгүй хэмээсэн. Сингапурын Дээд шүүх маргагч талын гомдлын дагуу хэргийг хянаад Арбитрын шүүх Хятадын хуулийг *lex loci arbitri* зарчмын дагуу хэрэглэсэн байх тул энэ үндэслэлд хамаарахгүй хэмээн шийджээ. Арбитрын харьяалан шийдвэрлэх маргаан гэж тооцогддоггүй маргааны төрөлд Сингапур улсын хувьд дампуурлын хэрэг ордог бөгөөд тодорхой төрлийн маргааны арилжааны шинжтэй эсэхийг нь гол шалгуур болгодог байна.

Нийтийн дэг журамд харшлах

Сингапурын ОУАХ-ийн 31 дүгээр зүйлийн (4)(b) заалтын 2 дахь хэсэгт “шийдвэрийг биелүүлэх нь Сингапурын нийтийн дэг журамтай зөрчилдөж байвал” гэх заалтыг тусгасан байдаг. Уг заалтын талаар Сингапурын Үндэсний их сургуулийн профессор Жан Хо өөрийн бүтээлдээ тус хууль нь нийтийн дэг журам гэх ойлголтод нэлээд өндөр босго тогтоосон бөгөөд шүүхийн практикаас харахад “манай нийгмийн шударга ёс болон ёс суртахууны суурь ойлголтод халдсан”, эсхүл хууль бус, залилангийн шинжтэйгээр нийтийн сайн сайхан байдалд хохирол учруулахаар байвал нийгмийн дэг журамд харшилсан үндэслэлээр шийдвэрийг биелүүлэхээс татгалзаж болно²¹ хэмээжээ.

*Бэрсвүүд Номинийс компанийн эсрэг Ляо Энэ Куатийн хэрэг*²² Сингапурын давж заалдах шатны шүүх нь цаашдаа гадаадын Арбитрын шийдвэрийг биелүүлэхэд тулгарах саадыг арилгах зорилгоор конвенцын 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн (b) заалтыг **нэлээд явцуу утгаар хэрэглэх шаардлагатай гэх агуулгаар байр сууриа илэрхийлж байжээ**. Тухайлбал зөрчилдөөний хэм хэмжээн дэх нийтийн дэг журам нь дотоодын эрх зүйн тогтолцоо дахь нийтийн дэг журмыг бодвол харьцангуй уян хатан байдаг тул гадаадын Арбитрын шийдвэрийг эсэргүүцэж буй тал нь нийтийн дэг журамд харшилсан үндэслэлээр шийдвэрийг биелүүлэхээс татгалзахын тулд дотоодын нийтийн дэг журам гэх ойлголтод тавьсан “өндөр босго”-ыг давах хэмжээний үндэслэлээ дэвшүүлж, батлах хэрэгтэй гэсэн байна. Иймд энэ үндэслэлээр гадаадын Арбитрын шийдвэрийг биелүүлэхээс татгалзсан тохиолдолд Сингапур улсын хувьд төдийлөн гараагүй байна.

3.4. Бүгд Найрамдах Солонгос Улсын эрх зүйн орчинд хийсэн судалгаа

БНСУ нь Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх тухай конвенц (Нью-Йоркийн Конвенц)-ийг 1973 оны 2 дугаар сарын 8-ны өдөр соёрхон баталж, 5 дугаар сарын 9-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Мөн БНСУ нь бие даасан Арбитрын тухай хуультай ба уг хуулийг анх 1966 онд баталсан боловч 1999 оны 12 дугаар сарын 31-ний өдөр ЮНСИТРАЛ-ын Олон улсын арилжааны арбитрын Загвар хуулийг (Загвар хууль) батлахын тулд бүхэлд нь шинэчлэн найруулсан байна.²³ Хамгийн сүүлд 2016 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Загвар хуулийн гол онцлог зохицуулалтыг тусгахын тулд уг хуульд нэмэлт өөрчлөлт орсон байна.²⁴

Олон улсын арбитрын шийдвэрийг биелүүлэхэд Үндэсний хууль тогтоомжтой зөрчилдөж буй тохиолдолд хэрхэн шийдвэрлэх

²¹ George A. Bermann, *Recognition and Enforcement of Foreign Arbitral Awards*, (Switzerland: Springer Nature, 2017), 829. ([Interpretation and Application of the New York Convention in Singapore \(researchgate.net\)](https://www.researchgate.net/publication/312222222))

²² *Liao Eng Kiat v Burswood Nominees Ltd* ([2004] SGCA 45 ([elitigation.sg](https://www.elitigation.sg/)))

²³ "South Korea: Receptive to Foreign Arbitration Awards?," Asian-Counsel Special Report on Dispute Resolution, Dec. 2009/Jan. 2010, 26.

²⁴ South Korea: International Arbitration (4th edition), 2.

https://www.jipyong.com/uploads/editor/file/2022/07/20220711032557_Comparative_Legal_Guide_South_Korea_JIPYONG.pdf

БНСУ-ын шүүх нь Нью-Йоркийн Конвенцод оролцогч улсад гаргасан гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай асуудлыг конвенцынхоо дагуу хянадаг. Конвенцын 5 дугаар зүйлд арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс татгалзаж болох хязгаарлагдмал үндэслэлүүдийг заасан байдаг. Тэдгээрээс БНСУ-д хамгийн олон удаа давтамжтай ашиглагдсан үндэслэл нь 5 дугаар зүйлийн 2(б) дох хэсэгт заасан тухайн арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх явдал нь тухайн орны нийтийн дэг журамд харшилж байвал ("ёс суртахуун ба нийгмийн дэг журам" нэрийн дор) хүлээн зөвшөөрөхгүй байх үндэслэл юм.

Арбитрын ажиллагааны талаар 5 дугаар зүйлийн 1(б) дэх хэсэгт заасны дагуу зохих ёсоор мэдэгдээгүй зэрэг бусад үндэслэлүүдээр татгалзсан тохиолдлууд ч бас байдаг. Арбитрын тухай хууль шинэчлэгдэхээс бараг 10 гаруй жилийн өмнө буюу 1990 онд арбитрын шийдвэрийг биелүүлэхээс татгалзах зорилгоор "нийтийн дэг журам" гэх ойлголтын явцуу тайлбарыг БНСУ-ын Дээд шүүхээс баталсан байна.²⁵ **Дээд шүүхээс энэхүү нийтийн дэг журам гэх ойлголтыг зөвхөн шийдвэр биелүүлэх улсын суурь ёс суртахууны итгэл үнэмшил болон нийгмийн дэг журмыг хамгаалах зорилготой гэж үзсэн.**²⁶

Датч компанийн нэхэмжлэлтэй Солонгос хариуцагчид хамаарах Цюрихт гарсан арбитрын шийдвэрийг биелүүлэхээр БНСУ-ын шүүхэд хандсан жишээ байдаг (Дараагийн хэсэгт энэ шийдвэрийг дэлгэрэнгүй авч үзэх болно.) ба түүн дээр үндэслэн шүүхээс арбитрын ажиллагаанд хэрэглэгдсэн гадаадын хууль тогтоомж нь БНСУ-ын дотоодын хууль тогтоомжийн заавал дагаж мөрдөх заалтуудыг зөрчсөн байсан ч энэ нь гадаадын арбитрын шийдвэрийг биелүүлэхээс татгалзах үндэслэл болохгүй гэж үзсэн байна. Зөвхөн тэрхүү шийдвэрийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх нь Солонгосын суурь ёс суртахуун, шударга ёсны үндсэн үзэл баримтлалд харшлах тохиолдолд л биелүүлэхээс татгалзах боломжтой.²⁷

Арбитрын шийдвэрийг биелүүлж буй Солонгос улсын жишиг

Онолын хувьд БНСУ-ын шүүхүүд арбитрын шийдвэр хаана гарсан эсэхээс үл хамааран арилжааны шинж чанартай гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхдээ ижил төстэй жишиг хэрэглэдэг. Шийдвэр гарсан харьяалал нь арбитрын ажиллагааны зохих процессыг хангаж, тохирсон стандартын дагуу БНСУ-ын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч л байвал тийм гадаадын арбитрын шийдвэрийг нь Конвенцод оролцогч талын харьяаллын хүрээнд гарсан шийдвэртэй адилхан хүндэтгэлтэй ханддаг.

Харин маргааны хүрээнээс шалтгаалан Конвенц үйлчлэхгүй арбитрын шийдвэрийн хувьд шийдвэрийг заавал хүндэтгэх тухай шаардлага тавигддаггүй. Ялангуяа БНСУ нь өөрийн бүрэн эрхт байдал ба дотоодын хууль тогтоомжийн дагуу арбитрт үл хамаарах тодорхой асуудлуудаас шалтгаалан арилжааны бус арбитрын маргааныг Конвенц үйлчлэх хүрээнээс хассан байна.²⁸

Уг хэсэгт БНСУ-ын гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлсэн чухал ач холбогдолтой кейсийг авч үзье.. **1995 онд Датчийн (одоо Нидерланд) хуулийг хэрэглэн Швейцарь улсын Цюрих хотод гарсан** арбитрын шийдвэрийг биелүүлэхээр Датч компани Солонгос хариуцагчийн эсрэг БНСУ-ын шүүхэд хандсан.. Хариуцагч уг шийдвэрийг эсэргүүцэхдээ Датчийн хууль тогтоомжийн дагуу 30 жилийн хөөн хэлэлцэх хугацаа нь Солонгосын хууль тогтоомжид зааснаас хамаагүй урт буюу аль хэдийн хүчингүй

²⁵ Korean Supreme Court Dec. No. 89Daka20252, 10 April 1990.

²⁶ "South Korea: Receptive to Foreign Arbitration Awards?," Asian-Counsel Special Report on Dispute Resolution, Dec. 2009/Jan. 2010, 27.

²⁷ Мөн тэнд, 28.

²⁸ Benjamin Hughes, "The recognition and enforcement of foreign arbitral awards in Korea", Dong-a journal of ibt law Vol.1:2, 110.

болох байсан тул энэ шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх нь БНСУ-ын нийтийн дэг журамд харшилна гэж маргасан байна. Гэсэн хэдий ч Дээд шүүх тус нөхцөл байдлыг нийтийн дэг журамд харшлах хэмжээнд хүрсэн гэж үзээгүй байна. Дээд шүүх уг шийдвэрийг эш татан арбитрын ажиллагаанд хэрэглэгдсэн гадаадын хууль тогтоомж нь БНСУ-ын дотоодын хууль тогтоомжийн заавал дагаж мөрдөх заалтуудыг зөрчсөн байсан ч энэ нь гадаадын арбитрын шийдвэрийг биелүүлэхээс татгалзах үндэслэл болохгүй гэж үзсэн байна.²⁹

Арбитрын шийдвэрийг биелүүлэхээс татгалзах үндэслэл

БНСУ Нью-Йоркийн Конвенцод харилцан ашигтай, арилжааны тайлбар хийж (i) Нью-Йоркийн конвенцод оролцогч бус улсад гаргасан арбитрын шийдвэр, (ii) БНСУ-ын хууль тогтоомжийн дагуу “арилжааны” гэж тооцогддоггүй маргаантай холбоотой арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан байна.³⁰

Арбитрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт шүүхийн шийдвэрийн дагуу гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлнэ гэж заасан байдаг. Тиймээс тухайн арбитрын шийдвэрийг биелүүлэхээр **БНСУ-ын шүүхээс шийдвэр гараагүй тохиолдолд гадаадын арбитрын шийдвэр нь БНСУ-д хууль зүйн практикийн ямар ч нөлөө үзүүлэхгүй байж болдог.** Гэвч БНСУ-ын Дээд шүүх Нью-Йоркийн конвенцод хамаарах арбитрын шийдвэр нь БНСУ-ын шүүхийн эцсийн болон баталгаажсан шийдвэртэй адил шүүхийн хүчин төгөлдөр (*res judicata*) байна гэж үзсэн.³¹

Арбитрын тухай хуулийн 7 дугаар бүлэг нь 37-39 зүйлийг хамардаг бөгөөд “Арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх болон биелүүлэх” тухай зохицуулсан байдаг. 37 дугаар зүйлд арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх, 38 дугаар зүйлд дотоодын арбитрын шийдвэрийн тухай, 39 дүгээр зүйлд гадаадын арбитрын шийдвэрийн тухай тус тус зохицуулсан байна. Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэхтэй холбоотой 39 дүгээр заалтыг дэлгэрүүлэн авч үзье.

<p>39 дүгээр зүйл (Гадаадын шийдвэр)</p>	<p>(1) Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенцод хамаарах гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх асуудлыг уг конвенцоор зохицуулна.</p> <p>(2) Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенцод хамаарахгүй гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 217 дугаар зүйл, Иргэний шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 27 дугаар зүйлд тус тус нийцүүлэн зохицуулна.</p>
<p>27 дугаар зүйл (Гүйцэтгэх шийдвэр)</p>	<p>(1) Шүүхийн шийдвэрийн зөв, буруу эсэхийг шалгахгүйгээр гүйцэтгэх шийдвэрийг гаргана.</p> <p>(2) Гүйцэтгэх шийдвэр гаргахыг шаардсан нэхэмжлэл нь дор дурдсан зүйлсийн аль нэгт нь хамаарах тохиолдолд хэрэгсэхгүй болгоно.</p> <ol style="list-style-type: none"> 1. Гадаадын шүүхийн шийдвэр нь эцэслэн гаргасан шийдвэр болсон нь нотлогдоогүй; 2. Гадаадын шүүхийн эцэслэн гаргасан шийдвэр нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 217 дугаар зүйлд заасан нөхцөлийг хангаагүй тохиолдолд.
<p>217 дугаар зүйл (Гадаадын шүүхийн)</p>	<p>(1) Гадаадын шүүхээс эцэслэн гаргасан шийдвэр, эсхүл ижил хүчинтэй болохыг хүлээн зөвшөөрсөн шийдвэр (цаашид "эцэслэн гаргасан шийдвэр гэх мэт" гэх) нь дараах бүх шаардлагыг хангасан тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөнө.</p>

²⁹ "South Korea: Receptive to Foreign Arbitration Awards?," Asian-Counsel Special Report on Dispute Resolution, Dec. 2009/Jan. 2010, 28.

³⁰ South Korea: International Arbitration (4th edition), 2.

https://www.jipyong.com/uploads/editor/file/2022/07/20220711032557_Comparative_Legal_Guide_South_Korea_JIPYONG.pdf

³¹ "South Korea: Receptive to Foreign Arbitration Awards?," Asian-Counsel Special Report on Dispute Resolution, Dec. 2009/Jan. 2010, 27.

шийдвэрийг хүлээн зөвшөөрөх)	<ol style="list-style-type: none"> 1. Тухайн гадаадын шүүхийн харьяалал нь БНСУ-ын хууль тогтоомж, гэрээний дагуу олон улсын харьяаллын зарчмын дор хүлээн зөвшөөрөгдсөн байх; 2. Хариуцагчид бичгээр гомдол гаргасан, урьдчилсан сонсох ажиллагааны мэдэгдлийг мэдэгдсэн, эсхүл хариуцагч нэхэмжлэлд хариу өгсөн байх; 3. Эцэслэн шийдвэрлэсэн шийдвэрийн агуулга, шүүх хуралдааны журам зэргийг харгалзан уг шийдвэрийг батлах гэх мэт нь БНСУ-ын сайн сайхан ёс суртахуун, нийтийн бусад дэг журамд харшлахгүй байх; 4. Гадаадын шүүхийн шийдвэр гарсан улс нь БНСУ-ын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх харилцан баталгаа байгаа, эсхүл гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх шаардлага нь БНСУ-ын хууль тогтоомж болон тухайн гадаад улсын хууль тогтоомж хоёрын дунд “тэнцвэрт байдлаас нэг их хол биш ба бодит ялгаа байхгүй” байх.
-------------------------------------	---

Үүнээс харвал БНСУ нь Конвенцод оролцогч улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх асуудлыг Конвенцын дагуу шийдвэрлэдэг бол оролцогч бус бусад улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх асуудлыг дотоодын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэдэг байна. Оролцогч улсын хувьд Конвенцын 5 дугаар зүйлд заасан үндэслэлийн дагуу арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс татгалзах боломжтой бол оролцогч бус бусад улсын хувьд Иргэний шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр татгалзах боломжтой.

Арбитрын ажиллагаа явагдсан болон шийдвэр гарсан газар нь БНСУ өөрөө байх тохиолдолд Арбитрын тухай хуулийн 36,37,38 дугаар зүйлүүдийг мөрдөх ба арбитрын ажиллагаа явагдсан болон шийдвэр гарсан газар нь Нью-Йоркийн Конвенцод оролцогч улс байх тохиолдолд Нью-Йоркийн Конвенц үйлчилнэ. Харин арбитрын ажиллагаа явагдсан газар нь уг Конвенцод оролцогч бус улс бол Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 217 дугаар зүйл, Иргэний шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон 27 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэгдэж байна..

ДҮГНЭЛТ

Гадаад улсын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх асуудал нь 1958 оны Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх тухай конвенцоор зохицуулагддаг эрх зүйн харилцаа ба тус олон улсын эрх зүйн баримт бичгийн зорилго нь нэгэнт шийдвэрлэгдсэн хэргийн талаар тогтоосон хугацаанд давж заалдах гомдол гаргаснаас бусад тохиолдолд маргааны талууд тухайн асуудлаар аливаа шүүхэд дахин хандах үндэслэлгүй гэсэн үг юм.

Дэлхийн улсууд олон улсын гэрээнд нэгдэн орж, соёрхон баталж, үндэсний хууль тогтоомжийнхоо нэгэн адил хүчин төгөлдөр даган мөрдөж байгаа тохиолдолд гадаадын шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх “үүрэггүй” ч түүнийг биелүүлэх нь олон улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа цаашид үргэлжлэх үндэс болох тул биелүүлэхгүй тохиолдол дийлэнхдээ үүсдэггүй байна.

Гэсэн хэдий ч нийтээр хүлээн зөвшөөрсөн буюу 1958 оны Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенцын 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар дэлхийн ихэнх улсад (Жишээ нь: ШХУ-ын Олон улсын эрх зүйн тухай хуулийн 27 дугаар зүйл, Сингапур улсын ОУАХ-ын 31 дүгээр зүйл, БНСУ-ын Арбитрын тухай хуулийн 217 дугаар зүйл) хүлээн зөвшөөрч даган мөрдөж байгаа гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээс татгалзах тодорхой үндэслэлүүд бий. Тус үндэслэлд: 1/шүүхийн эрх хэмжээ, 2/нийтийн дэг журам буюу public order-ыг зөрчсөн тохиолдолд гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхгүй байх эрхийг олгожээ.

Монгол Улсын дотоодын хууль тогтоомж болох Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зохицуулалтаас үзвэл гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх харилцаанд эрх зүйн эх сурвалжийн эрэмбийн хувьд олон улсын гэрээний зохицуулалтыг баримтлахаар байна гэж үзэж болохоор байна. Түүнчлэн зарим улс хоёр талт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ буюу Иргэний болон эрүүгийн хэргийн талаар харилцан туслалцаа үзүүлэх гэрээгээр “гадаадын шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс татгалзах үндэслэл”-ийг гэрээний нөхцөл болгон зохицуулдаг.

Япон улсын хувьд 1958 оны конвенцын гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээс татгалзах тухай зохицуулалттай төстэй байдлаар Арбитрын тухай хуульдаа “хүлээн зөвшөөрөхөөс татгалзах үндэслэл”-ийг хуульчилжээ. Мөн арбитрын шийдвэр гарсны дараагаар анхан шатны шүүхээс “шийдвэрийг биелүүлэх тухай” шийдвэр гаргаж баталгаажуулдаг. Энэ зохицуулалт нь Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн Арван дөрөвдүгээр бүлэгт заасан Арбитрын ажиллагаанд шүүх оролцох, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлд заасантай нэлээд төсөөтэй байхаас гадна Япон улс нь Арбитрын тухай хуулийн зохицуулалтаараа олон улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхээс татгалзах үндэслэлүүдийг заасан байна. Ингэхдээ арбитрын шийдвэр нь хуульд заасан биелүүлэхээс татгалзах үндэслэлийг “ноцтой” зөрчсөн байхаас бусад тохиолдолд биелүүлэхээс татгалздаггүй, заавал биелэгдэх ёстой эцсийн шийдвэр гэж тооцогддог.

ШХУ нь 1958 оны Гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх тухай конвенцын гишүүн улс тул тухайн баримт бичгийг хүчин төгөлдөр болгож 1965 оноос даган мөрдөж эхэлсэн байна. Түүнчлэн тухайн баримт бичгийн зохицуулалтыг илүү нарийвчлан дэлгэрүүлж Олон улсын хувийн эрх зүйн тухай хууль гэсэн баримт бичгээр арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, түүнийг биелүүлэх, биелүүлэхээс татгалзах үндэслэлүүдийг хуульчлан тодорхойлжээ. Дээрх 2 баримт бичигт нийтлэг байдлаар тухайн улсын нийтийн эрх ашгийг /нийтийн дэг журам буюу order public/ зөрчсөн эсхүл тухайн арбитрын шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаан биш байсан бол арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхээс татгалзаж болохоор зохицуулсан. Харин ШХУ-ын Олон Улсын хувийн эрх

зүйн тухай хуульд тус 2 үндэслэлээс гадна арбитрын шүүхийг хуульд нийцүүлэн байгуулаагүй бол, арбитрын шүүх эрх хэмжээгээ хэтрүүлэн нэхэмжлэлийн шаардлагад тусгаагүй асуудлаар шийдвэр гаргасан бол, талуудын процессын эрхийг хангаж тэгш эрхийн зарчмыг хэрэгжүүлээгүй бол биелүүлэхээс түдгэлзэж болохоор зохицуулжээ. Нэмж дурдахад, ШХУ-ын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байх үндэслэл нэлээд хязгаарлагдмал бөгөөд гарсан арбитрын шийдвэр ихэнх тохиолдолд эцсийн шийдвэр болж заавал биелэгдэх шинжийг олдог гэж дүгнэж болохоор байна.

Сингапур улсын хувьд олон улсын гэрээнд тусгагдсан гадаадын шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс татгалзах хоёр үндэслэлийг (маргааны зүйл нь арбитрын шүүхийн хяналтын объект биш байх, арбитрын шийдвэрийг биелүүлэх нь тухайн орны нийтийн дэг журамд харш байх) дотоодын Арбитрын тухай хуульдаа тусган хуульчилсан. Тус хуулийн ерөнхий агуулгыг Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх тухай 1958 оны конвенцын “тусгал” гэж хэлж болно. Нийтийн дэг журамд харш гэдгийг “манай нийгмийн шударга ёс болон ёс суртахууны суурь ойлголтод халдсан эсхүл хууль бус, залилангийн шинжтэйгээр нийтийн сайн сайхан байдалд хохирол учруулахаар байвал” гэж тодорхойлохыг оролдсон. Мөн шүүхээс шийдвэрлэсэн нэг тохиолдолд “энэхүү нийтийн дэг журамд холбогдох заалтыг явцуу утгаар хэрэглэх шаардлагатай” гэж үзэж байжээ. Тус улсын хувьд дээрх шалтгаанаар арбитрын шийдвэрийг биелүүлэхээс татгалзсан тохиолдол гараагүй байна.

БНСУ-ын хувьд бусад улстай адилаар энэхүү харилцаанд олон улсын гэрээг голлон баримталдаг ба “нийтийн дэг журам зөрчсөн” гэсэн үндэслэлээр хамгийн олон удаагийн давтамжтайгаар гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхээс татгалзсан байдаг. 1990-ээд онд тус “нийтийн дэг журам”-ын хүрээ хязгаарыг тодорхойлох зорилгоор БНСУ-ын Дээд шүүхээс тайлбар гаргасан ба ингэхдээ “нийтийн дэг журам гэдгийг явцуу утгаар буюу зөвхөн шийдвэр биелүүлэх улсын суурь ёс суртахууны итгэл үнэмшлийг хамгаалах” зорилготой гэж үзжээ. Улмаар БНСУ-д Япон улсын адил арбитрын шийдвэрийг биелүүлэхэд баталгаажуулах алхам чухал ба энэ нь шүүхийн оролцоотойгоор биелэгддэг. Түүнчлэн ихэнх тохиолдолд “нийтийн дэг журам” гэсэн ойлголтын хамрах хүрээ, түүний агуулгыг явцуу хүрээнд бусад улсын шүүхээс тайлбарлан ирсэн жишиг тогтжээ гэж үзэж болохоор байна.

ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж:

- Нью-Йоркийн Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенц, 1958 он.
- Арбитрын тухай хууль, 2017 он.
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017 он.
- Япон улсын Олон улсын арилжааны арбитрын тухай хууль, 1985 он.
- Япон улсын Арбитрын тухай хууль, 2003 он.
- Швейцарын холбооны улсын Олон улсын хувийн эрх зүйн тухай хууль, 1987 он.
- Бүгд Найрамдах Сингапур улсын Арбитрын тухай хууль, 1986 он.
- Бүгд Найрамдах Сингапур улсын Олон улсын Арбитрын хууль, 1994 он.
- БНСУ-ын Арбитрын тухай хууль, 2016 он.

Монгол хэлээр:

- Б.Тамир, *Олон улсын хувийн эрх зүй*, (УБ,2019).

Гадаад хэлээр:

- 仲裁法（平成十五年法律第百三十八号）。
- 近藤昌昭ほか『仲裁法コンメンタール』（商事法務、2003）。
- 谷口安平＝鈴木五十三編『国際商事仲裁の法と実務』（丸善雄松堂、2016）。
- 高杉直『日本における外国判決 および外国仲裁判断の承認・執行』法政論集 276号（2018）。
- Kazushige Ogawa, Introduction to Japanese Arbitration Act with Court Cases, [https://idrc.jp/images/link/Introduction%20to%20Japanese%20Arbitration%20Act%20with%20Court%20Cases%20\(Japanese\).pdf](https://idrc.jp/images/link/Introduction%20to%20Japanese%20Arbitration%20Act%20with%20Court%20Cases%20(Japanese).pdf).
- 東京地決平成 21・7・28(平成 20 年(仲)3号)LEX/DB 文献番号: 25451576、判タ 1302号 292 頁。
- 東京高決平成 30・8・1(金商 1551号 13 頁)。
- Dr.Reinmar, *New York Convention:Article-by-Article-Commentary* (Munchen, Germany: Hart Publishing, 2019) .
- *Hainan Machinery v Donald & McArthy* ([CLF1-96 \(channeo.sg\)](#))
- George A. Bermann, *Recognition and Enforcement of Foreign Arbitral Awards*, (Switzerland: Springer Nature, 2017), 829. ([Interpretation and Application of the New York Convention in Singapore \(researchgate.net\)](#))
- *Liao Eng Kiat v Burswood Nominees Ltd* ([\[2004\] SGCA 45 \(elitigation.sg\)](#))
- "South Korea: Receptive to Foreign Arbitration Awards?," Asian-Counsel Special Report on Dispute Resolution, Dec. 2009/Jan. 2010.
- South Korea: International Arbitration (4th edition). https://www.jipyong.com/uploads/editor/file/2022/07/20220711032557_Comparative_Legal_Guide_South_Korea_JIPYONG.pdf
- Korean Supreme Court Dec. No. 89Daka20252, 10 April 1990.
- "South Korea: Receptive to Foreign Arbitration Awards?," Asian-Counsel Special Report on Dispute Resolution, Dec. 2009/Jan. 2010.
- Benjamin Hughes, "The recognition and enforcement of foreign arbitral awards in korea", Dong-a journal of ibt law Vol.1:2,.
- "South Korea: Receptive to Foreign Arbitration Awards?," Asian-Counsel Special Report on Dispute Resolution, Dec. 2009/Jan. 2010.
- South Korea: International Arbitration (4th edition). https://www.jipyong.com/uploads/editor/file/2022/07/20220711032557_Comparative_Legal_Guide_South_Korea_JIPYONG.pdf
- "South Korea: Receptive to Foreign Arbitration Awards?," Asian-Counsel Special Report on Dispute Resolution, Dec. 2009/Jan. 2010.

Цахим хуудас:

- <https://investmentpolicy.unctad.org/>
 - <https://www.newyorkconvention.org/>
 - <https://www.swissarbitration.org/>
 - <https://www.tas-cas.org/en/general-information/>
 - <https://www.unil.ch/>
 - <https://dergipark.org.tr/>
 - <https://www.swissarbitrationdecisions.com/>
- <https://www.fedlex.admin.ch/>